# Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт орших “Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төслийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

**“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК**

2024 он

# ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ........ 5

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө........ 5

2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ........ 10

2.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 13

2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ........ 17

2.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ........ 18

2.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах ........ 20

## Зургийн жагсаалт

*Зураг 1. Судалгааны талбайн харагдах байдал* ...... 4
*Зураг 2. Судалгааны талбайн байршил* ...... 4
*Зураг 3. Сэлбэгийн агуулахад байрлах тос тосолгооны материал асгарсан үед хэрэглэх асгаралтын иж бүрдэл* ...... 8
*Зураг 4. Химийн бодисын агуулах, гадаах талбайн асгаралтын иж бүрдэл* ...... 8
*Зураг 5. Лабораторид байрлах самбарууд* ...... 9
*Зураг 6. “Түрээс” хэсгийн зүүн урд талд тариалсан мод* ...... 10
*Зураг 7. “Түрээс”-ийн хашааны баруун талд ажилчдын амрах хэсгийн тохижилт, мод тарихын өмнөх ба дараах байдал* ...... 11
*Зураг 8. Орчны тохижилтын хүрээнд “Түрээсийн хэсэгт мод тариалж, засч тохижуулсан амралтын хэсэг* ...... 11
*Зураг 9. ОУ-ын цэцэрлэгт хүрээлэнд бүх нийтийн мод тарих өдрөөр мод тарьж буй байдал, 2024.10.05* ...... 12
*Зураг 10. а. Гялгар уут болон цаасны хаягдал түр хадгалах цэг .. б. Мод болон төмрийн хаягдал түр хадгалах цэг* ...... 15
*Зураг 11. Аюултай хог хаягдал болох тостой хаягдал, химийн бодисын сав, баглаа түр хадгалах цэг* ...... 15
*Зураг 12. Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлын бүтэц* ...... 16
*Зураг 13. БГД-т хандивласан ширээ сандал, компьютер* ...... 18
*Зураг 14. Ажилчдын вакцинжуулалтад хамрагдсан байдал* ...... 19
*Зураг 15. Ажилчид цусаа хандивлаж буй байдал* ...... 19
*Зураг 16. Оршин суугчдад компанийн үйл ажиллагааг танилцуулж буй байдал* ...... 21
*Зураг 17. БГД-ын 25 дугаар хороонд компанийн үйл ажиллагааг танилцуулж буй байдал* ...... 21

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Барловорлд Монголиа” ХХК нь 1996 оноос Монгол улсад уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэгийг ханган нийлүүлэх, засварлах, түрээслэх үйл ажиллагаагаа сүүлийн 25 жилийн турш тасралтгүй явуулж байна. Үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Цогтцэций сум, Гурвантэс сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум зэрэг олон салбартай боловч Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт гол үндсэн үйл ажиллагаа явагддаг.

“Барловорлд Монголиа” ХХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн хуучнаар 4-р хороо, одоогийн 25-р хорооны нутаг дэвсгэрт нэг доор зэрэгцээ орших доорх 3 хэсэг газарт үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Нийслэлийн засаг даргын 2017 оны А/488 тоот захирамжаар олгосон 000001866 тоот газар ашиглах гэрчилгээтэй 7994 $м^2$ талбайтай газар
2. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/0623 тоот захирамжаар олгосон 0000082889 тоот газар ашиглах гэрчилгээтэй 14741 $м^2$ талбайтай газар
3. Өөрийн охин компани болох “Глобал шарын гол” ХХК-ийн эзэмшилд байдаг Нийслэлийн засаг даргын 2021 оны А/104 тоот захирамжаар олгосон 000028842 тоот газар эзэмших гэрчилгээтэй 9268 $м^2$ талбайтай газруудад үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 3 хэсэг газрын талбайн нийлбэр 32003 $м^2$.

Тус төсөл нь хүнд машин механизмын засвар үйлчилгээ хийж, хүнд машин механизмын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдаалдаг. Өөрийн гэсэн засвар үйлчилгээний төвтэй. Энэ төвийн зорилго нь уул уурхай болон бусад хүнд үйлдвэрүүдэд шаардлагатай хүнд даацын машин, механизмыг худалдах, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх, тэдгээрийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх юм. Зарим засвар үйлчилгээг хийхэд тухайлбал хөдөлгүүрийн гэмтэл, доголдлыг илрүүлэхэд лабораторид химийн бодис ашиглах шаардлага урган гардаг. Иймээс төсөл хэрэгжүүлэгч нь Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори байгуулжээ. Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори нь тосны болон хөргөлтийн шингэний дээжид ашиглалтын шинж чанарын шинжилгээг олон улсын стандартын шаардлагад нийцсэн технологиор хийдэг.

Нийт 300 орчим ажилтантай.

“Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төсөл нь 3 үндсэн хэсэгтэй.

***Төв оффис.*** Энд тус компанийн захирал, удирдах албан хаагчид суух бөгөөд мөн машин механизмын бүхий л засвар үйлчилгээ хийгддэг. Машины мотор болон бусад эд ангиудыг засах засварын цех, машин угаалга зэрэг үйлчилгээ энэ хэсэгт байрладаг.

***Түрээс.*** Машин механизмын зарим жижиг засвар хийгддэг. Мөн цахилгаан үүсгүүр, жижиг машин механизмыг энэ хэсэгт түрээсэлж худалдаалдаг.

***Баруун оффис.*** Тус байранд өөрсдийн худалдан борлуулж буй сэлбэг хэрэгслийг хадгалдаг агуулахтай, мөн оффисын ажилчид суудаг.




*Зураг 1. Судалгааны талбайн харагдах байдал*



*Зураг 2. Судалгааны талбайн байршил*

# 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Галын самбар, гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулж галын хоруудыг хугацаанд нь цэнэглүүлж байх, гал гарч болзошгүй газруудад анхааруулах тэмдэглэгээ, зурагт хуудас бэлтгэж байрлуулах | Агуулах, лаборатори, засварын газар, оффис зэрэг газруудад гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж галын хорыг цэнэглэж тогтмол цэнэглэж байна. |  |
| 2. | Химийн бодисуудын савны битүүмжлэлийг байнга шалгах | Лабораторийн ажилчид химийн бодисын агуулахад хадгалагдаж байгаа болон лабораторид хэрэглэж байгаа бодисуудын таглаа, бүрэн бүтэн байдлыг байнга шалгадаг. | |
| 3. | Агааржуулалтын системийн найдвартай ажиллагааг хангах, тогтмол шалгах, шаардлагатай үед засвар үйлчилгээг хийх | Агуулах нь бүрэн агааржуулах системтэй. Агуулахын температур нь бодисын хадгалах нөхцөлд тохирсон тогтмол температуртай байвал зохих учраас эйр кондийшн буюу халуун хүйтэн агаар үлээгчийг суурилуулсан. Химийн бодисыг зөв хадгалах горимын дагуу тус өрөөний температурыг өдөрт 2 удаа хянаж, тэмдэглэл хөтөлдөг. | |
| 4. | Химийн бодисын агуулахаас 6 метрийн зайд тамхи татах, ил гал гаргаж болохгүйг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ бүхий бүс татах | Шаардлагатай газруудад анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг наасан. | |
| 5. | Химийн бодисуудыг зөв хаягжуулж, хор аюулын лавлахад заасан зөвлөмжийн дагуу хадгалах | MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан агуулахад химийн бодисуудыг хор аюулын лавлахад заасны дагуу хадгалдаг. | |
| 6. | Шаардлагатай газруудад шингээх материал, асгаралтын иж бүрдэл | Химийн бодисын агуулах болон шатах тослох материал хадгалж буй агуулах, гадаах талбайд АНУ-д үйлдвэрлэгдсэн | Зургийг хавсаргав. |

| | | | |
|---|---|---|---|
| | бэлэн байлгах | BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгадаг. | |
| 7. | Химийн бодисын асгаралт болсон тохиолдолд шингээгч материалаар шингээж бохирдсон материалыг мэргэжлийн байгууллагаар устгуулах | 2024 онд химийн бодисын асгаралт явагдаагүй.<br>Хэрэв асгаралт явагдаж шингээсэн тохиолдолд химийн бодис арчсан шингээх материалуудыг мэргэжлийн байгууллага болох “Цэцүүх трейд” ХХК-д нийлүүлнэ. | “Цэцүүх трейд” ХХК-тай гэрээтэй ажилладаг. |
| 8. | Химийн бодис их хэмжээгээр асгарсан тохиолдолд ослын талаар мэдэгдэж яаралтай холбоо барих утасны жагсаалтыг байрлуулах | Бид асгаралтын журам HSE-SOP-05-02-01-д заасны дагуу асгаралтын хэмжээнээс үл хамааран мэдээлж, яаралтай цэвэрлэх үүрэг хүлээн ажилладаг. Мөн тухайн бодисын ХАЛМ /SDS/-д заасны дагуу ажилтан өөрийгөө хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт өмсөж тухайн бодистой харьцаж ажиллана. |  |
| 9. | Аюулгүйн ажиллагааны зааварчилгааг боловсруулж агуулахад ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах | MNS 4969:2000 стандартад нийцүүлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байрны өдөр тутмын зааварчилгаа өгдөг.<br><br>Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг улирлын онцлогоос хамааран жилд 2 удаа нийт 4 ээлжийн хувцсыг компанийн HSE-SOP-01-04-01 /Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, тэдгээрийг ашиглах/ журам-д нийцүүлэн тараадаг. |  |
| 10. | Химийн хорт болон аюултай бодисуудын Н-аюулын тэмдэглэгээ, Р-анхааруулах тэмдэглэгээ, сэрэмжлүүлэх үг, дүрс тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг агуулахад хадгалагдаж буй бодис нэг бүр дээр бүрдүүлэх | Химийн бодисын агуулахад хадгалж буй бодис бүрийн анхааруулах, хор аюулын тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг химийн бодисын агуулахад байрлуулсан. |  |
| 11. | Галын самбар, гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулж галын хоруудыг хугацаанд нь цэнэглүүлж байх, гал гарч | 1-д заасан арга хэмжээтэй давхацсан. | |

| | | | |
|---|---|---|---|
| | болзошгүй газруудад анхааруулах тэмдэглэгээ, зурагт хуудас бэлтгэж байрлуулах | | |
| 12. | Гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, галын хор хэрэглэх, гал түймрийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ажилчдад сургалт оруулах | Гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, сэргийлэх талаарх сургалтыг мэргэжилтнээр ажилчдад 1 удаа 60 минутын сургалт оруулав. |  |
| 13. | Болзошгүй аюул осол болон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас аюул осол тохиолдох, химийн бодис асгарах үед авах арга хэмжээний талаар ажилчдад сургалт орох | Аюул ослын үед авах арга хэмжээний талаар гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд оруулсан. Үүний хүрээнд батлагдсан бүлгийн гишүүд улиралд нэг удаа онцгой байдлын сургалт, сургуулилт хийдэг. Компанийн хэмжээнд нийт 7 цугларах цэгтэй. |  |
| 14. | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулах | БГД-ийн Онцгой байдлын газраар хянуулж, даргаар баталгаажуулсан. | ГХТ-өөг хавсаргав. |

**6. Химийн бодисын асгаралт болсон тохиолдолд шингээгч материалаар шингээж бохирдсон материалыг мэргэжлийн байгууллагаар устгуулах**

Химийн бодис асгарсан тохиолдолд ажилтнуудын арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан асгарсан бодисыг шингээгч оймс (socks), алчуур (pad), дэр (pillow), усны гутал, хамгаалах хувцас

зэргийг багтаасан АНУ-д үйлдвэрлэгдсэн BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгадаг.




*Зураг 3. Сэлбэгийн агуулахад байрлах тос тосолгооны материал асгарсан үед хэрэглэх асгаралтын иж бүрдэл*




*Зураг 4. Химийн бодисын агуулах, гадаах талбайн асгаралтын иж бүрдэл*

## 10. Химийн бодисын хаягжуулалт

Химийн хорт болон аюултай бодисуудын H-аюулын тэмдэглэгээ, P-анхааруулах тэмдэглэгээ, сэрэмжлүүлэх үг, дүрс тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг агуулахад хадгалж буй бодисууд дээр бүрдүүлсэн.




*Зураг 5. Лабораторид байрлах самбарууд*

## 2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Эзэмшил талбайн 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж бий болгох | Боломжит газруудад мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх (7ш мод)<br>Мод тарьсан талбайн доорх газрыг зүлэгжүүлэх, арчлах, цэцгийн мандал байгуулах | “Түрээс”-ийн хэсэгт гацуур мод тарьж ажилчдын амрах орчныг бүрдүүлж 50 сая төгрөгөөр тохижуулсан. | Зургийг хавсаргав. |
| 2 | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих | Өөрийн эзэмшил газарт тарих талбай байхгүй учир хороотой харилцан зөвшилцөж сонгосон газарт мод тарих, арчлах, ургуулах, 50ш | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 10 сарын 5-нд “Бүх нийтийн мод тарих өдөр”-өөр IC парк ОУ-ын цэцэрлэгт хүрээлэнд тэхийн шээг 100ш тарьсан. | Зургийг хавсаргав. |

1. Орчны тохижилт, ногоон байгууламж байгуулах хүрээнд эзэмшил талбайн “Түрээс”-ийн хэсэгт тэхийн шээг 100ш тарьж ургуулав.



*Зураг 6. “Түрээс” хэсгийн зүүн урд талд тариалсан мод*



*Зураг 7. “Түрээс”-ийн хашааны баруун талд ажилчдын амрах хэсгийн тохижилт, мод тарихын өмнөх ба дараах байдал*



*Зураг 8. Орчны тохижилтын хүрээнд “Түрээсийн хэсэгт мод тариалж, засч тохижуулсан амралтын хэсэг*

## 2. Тэрбум мод



*Зураг 9. ОУ-ын цэцэрлэгт хүрээлэнд бүх нийтийн мод тарих өдрөөр мод тарьж буй байдал, 2024.10.05*

## 2.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Бүх хог | Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах<br>- Төмрийн хаягдал<br>- Цаасны хог хаягдал<br>- Хуванцар хаягдал<br>- Тостой хаягдал<br>- Хоол хүнсний хаягдал<br>- Батарей<br>- Мод<br>- Шатах тослох материалын хаягдал<br>- Бусад хаягдал | Засварын цехүүдэд эх үүсвэр дээр нь хог ангилах 5 төрлийн хогийн сав байршуулсан.<br>Боломжтой бүх хог хаягдлыг ангилан ялгададаг. |  |
| 2 | Энгийн Энгийн хог хаягдал | Энгийн хог хаягдлыг ТҮК-тай гэрээгээ сунган гэрээний дагуу зайлуулж байх | Ангилан ялгаад 2-догч түүхий эд авах цэгт тушаагаад, дахин ашиглах боломжтойг дахин ашиглаж үлдсэн энгийн хог хаягдлыг БГД-ийн “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, “Баянгол тохижилт өргөө” ТҮК-д нийлүүлдэг. | Гэрээ хавсаргав. |
| 3 | | Ахуйн шингэн хаягдлыг “Том масс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байх | Баруун оффис болон Төв оффисын хэсэг төвийн бохирын шугамд холбогдсон. Түрээс хэсгийн бохирыг үргэлжлүүлэн “Том масс” ХХК-тай гэрээлэн соруулж төв цэвэрлэх байгууламжид нийлүүлж байна. | Гэрээ хавсаргав. |
| 4 | | Төслийн хашаанд байгаа хог хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах | Хог хаягдлыг түр цуглуулах талбай дээр байнгын нэг ажилтан ажилладаг бөгөөд цугларсан хаягдлыг ангиллын дагуу прессэлж, дахин боловсруулах газарт гэрээний дагуу хүлээлгэн өгч байна. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | |  | |
| 5 | | Хоол хүнсний хаягдлыг бордоо болгох | Хоол хүнсний хог хаягдлыг бордоо болгох яс бутлах төхөөрөмж суурилуулсан. Гал тогооноос гарсан тахиа, хонь, үхрийн гээд бүх төрлийн ясыг буталж жижиглэх зориулалтын машиныг худалдан авч суурилуулсан. | |
| 6 | Аюултай хог хаягдал | Химийн бодисын сав, баглаа боодол, үлдэгдэл, химийн бодис арчсан даавуу, хувцас зэрэг аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллага болох Цэцүүх трейд ХХК-тай гэрээлэн устгуулах | Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа, тостой даавуу, тостой хувцас зэрэг аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-тай гэрээлэн устгуулж байна. | Гэрээ хавсаргав. |

### 1. Хог хаягдлаа ангилан ялгах

Хог хаягдлаа ангилан ялгаж түр хадгалан мэргэжлийн байгууллагуудад нийлүүлдэг. Тухайлбал: гялгар уут, цаасны хаягдал гэх мэт дахин боловсруулагддаг хог хаягдлыг хоёрдогч түүхий эд боловсруулдаг “Түвшин сайхан” ХХК-д, химийн бодисын үлдэгдэл, сав баглаа, тостой хаягдлыг “Цэцүүх трейд” ХХК-д, мод, төмөр болон шил, лааз, хуванцар савны хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт, хаягдал батерейг Цэнгэг усны төвийн хаягдал батерей авах цэгт, хаягдал тосыг “Монпити Ойл” ХХК-д нийлүүлж үлдсэн энгийн хатуу хог хаягдлыг “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-аар зайлуулж байна.



*Зураг 10. а. Гялгар уут болон цаасны хаягдал түр хадгалах цэг б. Мод болон төмрийн хаягдал түр хадгалах цэг*




*Зураг 11. Аюултай хог хаягдал болох тостой хаягдал, химийн бодисын сав, баглаа түр хадгалах цэг*




*Зураг 12. Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлын бүтэц*

## 2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | | | | |
| 1 | - PM2.5, PM10<br>- SOx<br>- NOx<br>- COx<br>- Дуу шуугиан | - Баруун оффис<br>- Түрээс /оффис<br>- Төв оффис | 3-р улирал | Жилд 1 удаа | Худгуудаас дээж авч шинжлүүлэв. | Шинжилгээний хариу хавсаргах |

## 2.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | 2024 оны Ус ашиглуулах дүгнэлтийг Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулах | 2024 оны Ус ашиглуулах дүгнэлтийг 2024.02.28-ны өдөр Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулсан. | Дүгнэлтийг хавсаргав. |
| 2. | Дүүргийн ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах | Ус ашиглах гэрээг 2024.02.06-ны өдөр БГД-ийн ЗД-тай байгуулсан. | Гэрээг хавсаргав. |
| 3. | 2023 оны хаягдал усны дүгнэлтийг Туул голын сав газраар гаргуулах | 2023 оны “Хаягдал усны дүгнэлт”-ийг 2024.02.07-ны өдөр Туул голын сав газраар гаргуулсан. | Дүгнэлтийг хавсаргав. |
| 4. | Дүүрэгтэй Хаягдал усны гэрээ байгуулах | “Хаягдал усны гэрээ”-г 2024.02.26-ны өдөр БГД-ийн ЗД-тай байгуулсан. | Гэрээг хавсаргав. |
| 5. | Ажилчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах | - Ажилтнуудаа улирлын томуугийн дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулсан.<br>- Ажилтнууд жилд 2 удаа цусны донорт хамрагдаж, сайн дураараа цусаа хандивладаг. | Зургийг хавсаргав. |
| 6. | Нийгмийн хариуцлагын хүрээнд харьяа хороотой харилцан тохиролцож санал хүсэлтийг шийдвэрлэх | Дахин хэрэглэх боломжтой сандал ширээгээ БГД-ын 25-р хороонд хандивласан. Мөн компьютер хандивласан. | Зургийг хавсаргав. |





*Зураг 13. БГД-т хандивласан ширээ сандал, компьютер*



*Зураг 14. Ажилчдын вакцинжуулалтад хамрагдсан байдал*



*Зураг 15. Ажилчид цусаа хандивлаж буй байдал*

## 2.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд | Мэдээний агуулга | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид | Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тухай | 25-р хорооны оршин суугчид болон ахмад настангуудыг компани дээрээ авч ирж үйл ажиллагаа, байгаль орчны талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ танилцуулсан. Нийт 37 иргэн оролцсон. Мөн хорооны ЗД-д үйл ажиллагаар дэлгэрэнгүй танилцуулсан. | Зургийг хавсаргав. |
| 2 | БОМТ-ий биелэлтийн тайланг нийслэлийн БО-ы газраар дүгнүүлэх | Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай | Биелэлтийн тайланг хүргүүлж байна. | |












*Зураг 16. Оршин суугчдад компанийн үйл ажиллагааг танилцуулж буй байдал*



*Зураг 17. БГД-ын 25 дугаар хороонд компанийн үйл ажиллагааг танилцуулж буй байдал*

TSETSUUH
SINCE 1996

**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК**

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

**Огноо:** 2023 оны 5 сарын 3

**Гэрээний дугаар:** **Ш-23/068**


**Хүлээн авагч:**
**“Цэцүүх Трейд” ХХК**

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот “Цэцүүх” оффис, үйлчилгээний төв
**Утас:** +976 70179777, +976 70180632
**Цахим хаяг:** www.tsetsuuh.mn
**Регистрийн дугаар:** 2066521
**Цахим шуудан:** info@tsetsuuh.mn

**Үүсгэгч:**
**“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК**
**Хаяг:** Баянгол дүүрэг, 25-р хороо, баруун үйлдвэрийн 133, Барловорлд Монгола ХХК-ийн байр
**Утас:** 70187588
**Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 9019001129
**Регистрийн дугаар:** 2077361
**Цахим шуудан:** info@barloworld.mn

БАТЛАВ.
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

………………… /Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ.
"БАРЛОВОРЛД МОНГОЛИА" ХХК
ЗАХИРАЛ

……… /ШОН УОЛШ/

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 5 сарын 3-ний өдөр №  Ш-23/ 068 Улаанбаатар хот
Ү-

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас "БАРЛОВОРЛД МОНГОЛИА ХХК"-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Үйлчилгээ дэмжих газрын захирал албан тушаалтай Т.Жанибек бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний агуулга

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

### Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж өгнө.
2.5. Аюултай хог хаягдлын *савыг угааж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

________________ Хуудсыг баталгаажуулсан: ________________

2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

## Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2023 оны 5 сарын 3 өдрөөс 2024 оны 5 сарын 2 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
3.3. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлоно.
3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
3.7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
3.8. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 10 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн **Голомт банкны 1715132986** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.

4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
4.1.9 Аюултай хог хаягдал хүлээн авах ажиллагаанд өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцна.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
4.2.8 Аюултай хог хаягдал хүлээн авах ажиллагаанд өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцна.

## Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэнэ.
5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.

Хуудсыг баталгаажуулсан:

5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

## Зургаа. Өмчлөх эрх шилжих

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

## Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул

зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.

8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

**Ес. Бусад зүйл**

9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Үүсгэгч талыг төлөөлж:
БАРЛОВОРЛД МОНГОЛИА ХХК-ийн
Хуулийн газрын захирал

Гарын үсэг / Signature

____________ / Д.Инжинааш /

BARLOWORLD MONGOLIA LLC
THE LEGAL DIVISION

Үйлчилгээ дэмжих газрын захирал

____________ / Т.Жанибек /

Суурин утас: 70187588
Гар утас: 99118768
Регистер: 2077361
УБ гэрчилгээний дугаар: 9019001129
Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар: 0002044
Хаяг: Баянгол дүүрэг, 25-р хороо, Баруун үйлдвэрийн гудамж-133, Барловорлд Монголиа ХХК-ийн байр
Email хаяг: info@barloworld.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга

____________ / Б.Дарамбазар /

Суурин утас: 70189778
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр
Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn
Шуудангийн хаяг: ШХ-1138

____________ Хуудсыг баталгаажуулсан: ____________

*"Цэцүүх Трейд" ХХК, "...................................... " ХХК-ийн хооронд*
*байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх*
